

Аж төрөх  
ухаан

Г.Ловор

# ЭВТ ДӨРӨВ



I  
ангийнханд  
зориулав

**Г.Ловор**  
**Эвт дөрөв**

*Бага сургуулийн 1-р ангийн сурагчдад зориулав.*

Зураач	Л.Зулбадрах Д.Сугархүү
Хянан тохиолдуулагч	О.Мөнхтуяа
Хянагч	Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Н.Хөдөлмөр Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

## Эвт дөрөв

Эрт цагт юм гэнэ билээ. Дөрвөн хүүтэй нэг өвгөн байжээ. Тэр дөрөв,

- Хонио хэн хариулах вэ, тугалаа хэн харах вэ, аргал хэн түүх вэ? гэхчлэн ажил болгон дээр "би чи"- дээ хүрч муудалцана.



Үүнийг ажигласан настай эцэг нь:

- Тэгж болохгүй ээ. Ахаа алд хүндэл, дүүгээ дэлэм хүндэл гэдэг алтан сургаал байдаг юм.

- Бас энэ сургаалтай  
адил нэгэн үлгэр байдгийг  
та нарт ярьж өгье.



Нэгэн ойд бич, тагтаа, туулай, заан дөрөв уулзаж  
гэнэ. Тэд нас ахих тусам ядарч туйлдаж яваагаа  
ярилцжээ. Тэгтэл бич:

- Бидний хэн нь ахмад нь юм бол оо? Түүнийгээ хүндэлж, хоол ундыг нь дөхүүлж өгч байя гэж санал гаргаж гэнэ.

Заан дэргэдэх бүдүүн модыг шөргөөж,

- Намайг тугал байхад энэ мод надтай чацуухан байсан, одоо өндөр болжээ гэхэд бич,

- Би монш байхдаа түүн дээр гарч тоглоё гэхэд мөчир нь даахааргүй байсан гэв. Туулай:

- Намайг бөжинхий байхад энэ мод дөнгөж үндэслэж байв. Би үндсийг нь мэрг шүднийхээ чилээг гаргадаг байсан гэж ярив. Харин тагтаа,

- Би энэ модны үрийг зууж яваад энд унагасан юм. Тэгээд энэ мод ургасан даа гэсэнд заан, бич, туулай гурав түүнийг хүндэтгэн толгой мэхийн ёслол.

Ингээд хамгийн ах нь тагтаа, дүү нь туулай, туулайн дүү бич, бичний дүү заан болохоо мэджээ. Тэгтэл бич бас,

- Бид эв найртай, ахмадыгаа хүндэтгэж явдгаа бусад амьтдад яаж мэдэгдэх вэ? гэв. Тэгтэл заан:

- Дүү нь ахыгаа үүрч явбал хүндэтгэлийн дээд тэр хэмээн өгүүлэв.

Бүгд зөвшөөрч, заан өөрөөсөө ах бичийг нуруун дээрээ гаргалаа. Бич өөрөөсөө ах туулайг мөрөн дээрээ гаргав. Туулай өөрөөсөө ах тагтааг нуруун дээрээ суулгалаа.

Ингэж явах нь бусад амьтдад бие биенээ хүндэлж, эв найртай байхын үлгэр болов. Үүний ачаар тэд өндөр модонд ургасан үр жимсэнд төвөггүй хүрч, түүнийг бүгдээрээ хувааж идэхэд ч хялбар болж гэнэ ээ.



Ингэж ярихад өвгөн хэдэн хүүхдээ ээлжлэн харвал отгон хүү нь,

- Ааваа, бид таны сургаалыг дагая. Эв түнжингүй залхуу байдлаа засъя гэсэнд дунд хүү нь,

- Тэгвэл бид тэр амьтад шиг эвтэй найртай амьдардгаа бусдад яаж харуулах вэ? гэв. Өвгөн:

- Эвтэй найрамдалтай байж, ажлаа хамжиж хийдэг бол адуу мал ч өсөж, айл гэр ч дэгжинэ. Айл өрх дэгжвэл улс орон хөгжихийг хүн бүхэн хараад мэднэ дээ гэжээ. Тэр цагаас хойш тэд ажил бүхнээ миний чиний гэлтгүй хамжиж элбэн хийдэг болов. Түүний ачаар идэж уух, өмсөх зүүхээр элбэг хангалуун амьдарч, нутаг хошуундаа гайхагдах болж гэнэ ээ.



## **Бага сургуулийн 1-р ангийнханд зориулав.**



*Гэр бүлийн өдөр тутмын амьдралд хүүхэд идэвхтэй оролцож эдийн засгийн “Цагаан толгой”-д суралцана.*



*Гэр бүлийн хамтын хөдөлмөр хүний цаашдын амьдралын чухал сургууль болдог.*



*Гэр бүлийн хүрээнд аав, ээжийн эрхэлдэг ажил хөдөлмөр хүүхдэд аж төрөхийн хичээл болдог.*



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл”-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.